

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гомбодорж	Дугаар	L120
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Эрдэнэцагаан
Төрсөн газар	Эрдэнэцагаан	Төрсөн он	
Ажил мэргэжил	Эрдэнэцагаан сумын дунд сургуулийн багш		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Егүзэрийн хийд, Хавхчин хурал, Хөхтийн хурал	Сүм хийдийн дугаар	СБЭЦ 003, СБЭЦ 002
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 23	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Егүзэрийн хийд, Хавхчин хурал, Хөхтийн хурал

-Эрдэнэцагаан сумд Егүзэрийн хийд, Чоно голын хийд гэж байсан байна?

Егүзэрийн хийд, Чоно голын хийд гэж ингэж болохгүй. Энэ нэг л хийд л дээ. Би хийдийн талаар товчхон танилцуулга өгчихье. Тэгэхлээр энэ нутаг бол Монгол орны зүүн өмнөд талын хэсэг Хурц вангийн хошуу гэдэг нэртэй Сэцэн хан аймгийн үед 1691-1922 он хүртэл байсан. Сүүлдээ хувьсгалын жилүүдэд Дорнод аймагт харъяалагдсан. 1941 онд Жавхлант шарга гэж аймаг байгуулагдаад 1943 онд Сүхбаатар аймаг гэж байгуулагдахад Дорнод аймгаас тасарсан ийм түүхтэй. Энэ хийд бол 1780 -1929 он хүртэл ажиллаж байсан. 220-иод жилийн өмнө буюу Манжийн Тэнгэрийг тэтгэсний 44 он/1780/ цагаан хулгана жил Халхын Сэцэн хан аймгийн сайд Ренчиндоржийн хошуу, 1879 оноос Хурц ван Түвдэн засгийн хошуу гэж нэрлэх болсон байгаа. Эдүүгээ Эрдэнэцагаан сумын төвд байгаа Чоно голын хойд дэнж дээр мянга гаруй лам, таван дацантай анх байгуулагдсан. Таван дацан гэдэг нь Манба, Чойр, Жүд, Чамба, Дүйнхор, гэсэн ийм таван дацан байсан. Мөн таван хамсан буюу бригад гэж нэрлэдэг байсан юм билээ. Тэгээд Дархан цорж Лувсанданзанчүлтэмсамбуу гэдэг ийм том лам байсан байна. Хийдийнх нь том хувилгаан ноён Цорж Сономравдан, Тойн лам Жалцан-Иш, Дамдин бишрэлт

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дугаржав гэдэг хүн байсан байна. Халзанширээт,33 Шавран гэж байсан байна. За ингээд сүмээс гадна бол Лавран, Цогчин дуган, Нүгний гэсэн хийдтэй холбоотой барилга байгууламжууд барьж энгэр газар байгуулагдсан хийд 1000 гаруй ламтай байсан учир Энгэр мянгат гэж нэрлэсэн түүхтэй юм билээ. Егүзэр хутагтын хийд нь Халх Монголд манжийн хааны зарлигаар байгуулагдсан томоохон хийд гэж үздэг юм байна. Манжийн Тэнгэрийг тэтгэсний 45 он буюу 1781 онд Өвгөн Егүзэрлүвсанбалдан гэдэг лам анх байгуулж байсан түүхтэй юм билээ. Сая биеэрээ ирээд хоёр, гурав хоногийн өмнө буцсан Донойн Равдан гэдэг хүний номон дээр бичсэн байгаа. Тэр хүн бол энэ хийдийн тухай бүгдийг нарийн ярьсан байдаг юм. Одоо энэ хийдийн чинь зүүн талд суварга байгаа. Энд тогтмол их хурал уншлагатай байдаг. Цогчэн дуган түүний баруун өмнө өдөр болгон тахилга уншлагатай. Егүзэр ламын догшин улаан сахиус нь зүүн тийш харсан цэвэр цэмцгэр жижиг сүм. Зүүн талд нь тэр үеийн өөдөөс харсан мөн нэг жижиг сүм байжээ. Энэ хоёр сүмийн урд талд том хонх дотор нь зүүсэн хоёр ижил жижиг сүм, түүний урд талд баруун, зүүн тийш хөндлөн барьсан жижиг сүм байдаг байв. Энэ хийдийн сүм, цогцолборын сонор соргогийн харуул болсон хоёр хоёроороо өөд өөдөөсөө харж байрласан, буг, чөтгөр шуламсыг саатуулж барьж залхаан цээрлүүлж байгааг харуулсан Махранз гэдэг дөрвөн бурхан байдаг байсан. Цогчэн дуганы ард Жүдийн дацан сүм байсан. Эдгээр сүм цогцолбор нь гадуураа хөх тоосгон хэрмэн хашаатай, хэрэм нь их дуганаасаа баруун зүүн талаар ордог жижиг хаалгатай байсан. Их дуганы цогцолбор болон жасаас баруун хойш одоогийн сумын холбооны байрны орчим Егүзэр хутагтын өндөр цагаан суврага байсан бөгөөд суварганы оройд алтан ганжиртай, ганжирийн хоёр талд өөд өөдөөсөө харж амгалан тайван хэвтэж байгаа хоёр бодь гөрөөстэй байсан. Суваргад хурал ном төдийлөн хурдаггүй, дотор нь ганжуур, данжуур зэрэг хүнд зузаан ном судрууд хадгалагдана. Хийдийн баруун хойд захад Лавран хоёр давхар сүм, зүүн талд Гэсэрийн сүм байдаг байлаа. Егүзэрийн хийдийн Монголын бусад хийдээс гол ялгаатай нь нэг онцлог нь жил бүрийн 4-р сарын 15-аас гурван өдрийн турш хуралддаг жүдва буюу 15-ны тахилга гэдэг хурал байсан. Уг тахилгыг үйлдэхдээ бурханы орон, намжидын аймаг, хүн төрөхтний аж байдлыг өөх, тос, мод, цай зэрэгээр хийж хөдөлгөөнтэй харуулдаг байсан нь нэн сонин. Энэ тахилгад хэрэглэх хиймэл уул, бурханы дүрс, ан амьтан, сүм дуган, хүн мэтийн дүрсийг нутгийн урчууд, дархчууд жил бүр урлан бүтээж шинэчлэн баяжуулдаг байлаа. Бүр хүүхэлдэйн тоглолт шавхуу юм хийдэг байсан байгаа юм, Мөн хийд амьтны хүрээлэн, зоо парк, ажилуулж түүндээ халуун орны сармагчин, тогос зэрэг гоёмсог олон амьтад байлгадаг байсан байгаа юм.Егүзэрийн хийдээс гадна Хурц вангийн хошуунд Шарын шашины хурал, сүм хийдүүд олон байсан. Жишээ нь Ховдын голд Хөхдийн хурал, Хонгорын голд Хавхчин хурал, Баянзүртэд Тайж нарын хурал, Баянзүрт гэдэг нь сумын төвөөс 50-60 км газар бий. Яг тэр Лхачинвандад уулын цаана хилийн цаана байгаад хэлмэгдүүлтэд ороогүй өртөөгүй гэдэг. Лхачинвандадад Онхчин хурал гэж байжээ. Егүзэрийн хийдийн сүүлчийн захирагч нь зарлигаар зассан зүүн хязгаарыг байцаан үзэж илбэн тохинуулах сайд, ачит лам бадарсан эрдэнэ мэргэн хамба дагуулсан чин зүтгэлт үнэн сүжигт номч мэргэн эрдэнэ гэгээн Егүзэр хутагт Галсандаш байсан юм. Тэрбээр Монголын тамгатай 13 хутагтын нэг байсан. Галсандаш 2 төрийн сайд байсан хүн. Өөрөө Хар хоринд очиж зориуд судалгаа хийж байлаа.

-Тайж нарын хурал, Онхчин хурал нь хаана хаана байсан? Түүр нь мэдэгдэх болов уу?

Түүриуд мэдэгдэнэ. Гэхдээ Лхачинвандад уул хилийн цаана байдаг. Тэнд бол түүр яг хаана байдгийг нь мэдэхгүй. Тайж нарын хурал эндээс 50 гаруй км газар байсан. Сүм дуган байгаагүй. Манай аав насаараа сум нэгдлийн дарга хийж байсан тэгээд надад материалаа үлдээсэн.

Мөн надтай хамт ажиллаж байсан түүхийн багш хүн бас их юм цуглуулсан байсан тэр хүмүүсийн баримтжуулсан материалаас авч байсан бодтой зүйл. Хавхчин хурал бол эндээс 20 хэдэн км Хонгорын гол гэдэг газар байсан одоо түүр

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

нь ил бий. Хөхдий хурал бол эндээс 20 хэдэн км газар 7-р багийн урдхан бий. Тайж нарын хурал бол эндээс 50 гаруй км-т байдаг. Овоо бол янзаараа. Егүзэрийн хийдийн тайж нар очиж тахидаг л байсан газар тэрнээс сүм байгуулсан юм бол байхгүй. Хурлаа хурж уншлагаа хийдэг түр гэр дуган барьдаг л байсан байх. Ер нь энэ нутагт хувилгаан ламуудын тахидаг байсан тэднээр нэрлэгдсэн овоонууд бий. Жишээ нь Чой ламын цагаан овоо, Ширээтийн баян цагаан гэж халзан Ширээт ламаар нэрлэсэн. Энэ овоогоо Ширээт лам нь тахиж морь уралдуулж хүүхдүүдэд бэлэг өгдөг байсан.

Манай энд Нүхтийн уурхай гэж байгуулагдаж байгаа юм. Тэр уурхайн дэргэд Егүзэр хутагтын мэндэлсэн газар байдаг, Энэ жил тэр газарт нь 4 талдаа жижиг голдоо том суварга босгосон. Нутгийн ардууд ч оролцсон уурхайхан ч газар лусаа аргадаж хөрөнгө оруулалт хийсэн байх.

-Онхотын хурал аль заставтай ойрхон байна вэ? Заставаар нь дамжуулж олж болох болов уу?

Онхотын хурал хилийн 4-р заставтай ойрхон байгаа. Бичигтийн застав Хилийн зурваст ойрхон.

Бяруут, Далай хамар, Өндөр хамарт сүм хийд байсан уу?

Бяруут, Далай хамар гэдэг бол сумын төвөөс 50-60-аад км байгаа. Дээр үед хил, гааль чанга байх үед айлууд нутагладаг байсан.

Бяруут гэдэг нь Урт сум, Далай хамар гэдэг нь Зотол сум байрлаж байсан газар. Нэг үе сумыг уул овооныхоо нэрээр нэрлэж байлаа ш дээ. Урт гэдэг нь зүүн талдаа орно. Тэнд хийдийн туурь гэх зүйл байхгүй. Настангуудын ярьж байгаагаар 1945 онд Өвөрмонголын Өөртөө Засах Орны Шилийн гол аймгийн зүүн үзэмчин хошууны нэг баг орж ирж байсан. Тэрний үлдэгдэл Диваасамбуу гуай, Шагж гуай байна. Улаанбаатарт Пэлжээ, Нямбуу гээд олон лам нар байсан. Хойно Тохойн хийд гээд нэг хийдийн туурь байх ёстой тэнд лам нар ирээд байдаг байсан.